



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 09 өдөр

Дугаар A/314

Мандалговь

Г

Зардал гаргах тухай

Т

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн A/171 дүгээр тушаал, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 1/1085 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Барилга, хот байгуулалтын дэд сайд Б.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчид 2019 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Англи Улсад газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, орон зүйн өгөгдөл, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтийн хүртээл болгох, шинэ технологи нэвтрүүлэх, хаягжуулалт, газар төлөвлөлт, хот байгуулалтын чиглэлээр туршлага судалж, сургалтад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Э.Чагнаадорж оролцох тул сургалтын зардал 8,173,296 (найман сая нэг зуун далан гурван мянга хоёр зуун ерэн зургаа) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Сургалтын зардалд шаардагдах 8,173,296 (найман сая нэг зуун далан гурван мянга хоёр зуун ерэн зургаа) төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ахлах нягтлан бодогч (Д.Эрдэнэболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



48819 810